



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/93.

Ховд

Зах, худалдаа үйлчилгээний төвүүдийн
үйл ажиллагааг нээх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор үйл ажиллагааг нь түр хязгаарласан зах, худалдаа, үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 10:00 цагаас эхлэн нээн ажиллуулсугай.

2. Зах, худалдаа, үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг нээсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн яамнаас өгч буй шинэ коронавирус /ковид-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжүүдийг чанд баримтлан үйлчилгээ үзүүлэхийг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Дээрх захирамжинд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Ховд хотын захирагч бөгөөд Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

